



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР**

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

┌ “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн
байгуулалтын жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, эдийн засгийн өсөлтийг хангасан, аюулгүй, найдвартай тээврийн дэд бүтцийг хөгжүүлж, салбарын бүтээн байгуулалтыг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

1.2024 оныг Зам, тээврийн салбарт “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил” болгон зарласугай.

2.“Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил” болгон зарласантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллага, салбарын төрийн өмчийн компаниуд дарга, захирал нарт дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд:

2.1.Зам, тээврийн салбарт бүс нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн тээвэр, логиستيкийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, бүх төрлийн тээврийн ачаа, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлийг баримтлан ажиллах;

2.2.Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөлд тусгах бүс нутгийн хөгжлийг дэмжих тээвэр, логиستيкийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын зорилт, арга хэмжээг Шинэ сэргэлтийн бодлого, бусад хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэн тусгуулах арга хэмжээ авах;

2.3.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд салбарын бодлогыг тусгах зорилгоор “Бүсүүдийг холбох тээвэр, логиستيкийн дэд бүтэц” салбарын хэлэлцүүлгийг зохион байгуулж, бүх талын оролцоог хангах;

2.4.Бүсчилсэн хөгжлийг дэмжих салбарын бүтээн байгуулалтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлон шийдвэрлэх;

2.5.Харьяа байгууллага, салбарын төрийн өмчит компаниуд “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг сар бүрээр нарийвчлан төлөвлөн, батлуулж, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг улирал бүрээр тайлагнах;

2.6.Шинэ сэргэлтийн 5 тойрог хөтөлбөрийн хүрээнд Бүсийн хөгжлийг дэмжих хил холболтын төмөр замууд, төмөр замын шинэ коридоруудын бүтээн байгуулалт, аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох, авто замын шинэ коридор байгуулах,

0800000001

орон нутгийн нисэх буудлуудыг өргөтгөн шинэчлэх төслүүдийг эрчимжүүлэхэд онцгой анхаарч холбогдох ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;

2.7.Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төслийн мэдээллийн программ хангамжийг шинэчлэн, дэвшилтэт технологи ашиглан гүйцэтгэлийн хяналтыг сар бүр тайлагнах, гарч буй хүндрэл бэрхшээл, шийдэл, саналыг тогтмол мэдээлэх;

2.8.Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон шинэ техник технологи нэвтрүүлэх, стандарт норм, дүрэм журмыг шинэчлэх, шинээр боловсруулах ажлыг эрчимжүүлэх;

2.9.Харьяа байгууллагууд хэрэгжүүлж буй бүтээн байгуулалтын ажлын явцын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ, байгууллагын цахим хуудсаар мэдээлэх, сурталчлах ажлыг тогтмолжуулах;

2.10.Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажиллах орчин нөхцөл, шинэ техник, технологи, инновацын шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

2.11.Салбарын бүтээн байгуулалтын хүрээнд бүс, орон нутагт бий болох ажлын байр, орон нутагт шилжин ажиллах ажилчдын тооцоог гаргаж нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого, шийдэл боловсруулж, хэрэгжүүлэх;

2.12.Салбарын судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэл, инновацын төвийг байгуулах судалгааг хийж, эрхзүйн орчныг бүрдүүлэх.

2.13.Салбарын хүрээнд харьяа байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил, аргазүйн зөвлөмжөөр хангах, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны газар, нэгжүүдэд даалгасугай.

3.Бүсчилсэн хөгжлийг дэмжих салбарын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлд тавих явцын хяналт, шалгалтыг сайжруулах, хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх, хариуцлага тооцох, тайлагнах механизмыг боловсронгуй болгохыг Салбарын хяналтын газар (Б.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг улирал тутам танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

САЙД С.БЯМБАЦОГТ

